

2024 оны 4 сарын 25-ны өдөр

№ 14

Улаанбаатар хот

Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.2, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.6, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.2, 8.6.12, 8.6.23, 8.10 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 4 сарын 25-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Компани нь нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100,000 (нэг зуун мянга) ширхэг, нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй өрийн хэрэгслийг (“Сэндли Бонд 2.0”) Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалахаар гаргасугай.
- Нээлттэй хүрээнд олон нийтэд санал болгох Бондын хэмжээ, төрөл, хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт болон бусад нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
- Бондын эргэн төлөлтөд дор дурдсан хувьцаа болон газар эзэмших эрхийг толгой компани “Монголын финтек групп” ХК холбогдох хууль, журам, тогтоолын дагуу барьцаалуулж, баталгаа гаргаж буйг дурдсугай.

Хувьцаа:

№	Барьцаа хөрөнгийн нэр	Барьцаалуулагчийн нэр	Тоо, ширхэг	Барьцааны зүйлийн үнэлгээ
1	"Сэндли ББСБ" ХК-ийн энгийн хувьцаа	"Монголын финтек групп" ХК	111,785,000	СЗХ-ны журамд зааснаар Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцсон үнэлгээний 70%-иар тооцох.

Газар эзэмших эрх:


№	Барьцаа хөрөнгийн нэр	Хаяг талбайн хэмжээ	Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар	Хөрөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээ
1	Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар	Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо 406 хаягт байрлах нэгж талбарын 4401010485 дугаар бүхий 10000 м.кв газар эзэмших эрх	Г-0000237626 Э-0714002972	Хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээний “Файн Эстимэйт ХХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хөрөнгийн үнэлгээний тайланг үндэслэх
2	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай	Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо 320 хаягт байрлах нэгж талбарын 4401002556 дугаар бүхий 1200 м.кв газар эзэмших эрх	Г-0000237326 Э-0714002967	

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн тогтоолд дурдсан үүргийн дагуу Компанийн Гүйцэтгэх захирал нээлттэй хүрээнд Бонд гаргахтай холбоотойгоор Үндсэн андеррайтераар “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК, туслах андеррайтераар “Райнос инвестмент ҮЦК” ХХК, “Голомт капитал ҮЦК” ХХК, Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН, Аудитын дүгнэлт гаргах байгууллагаар “Хүлэгтхүннү аудит” ХХК-ийг тус тус сонгож, холбогдох гэрээ байгуулан ажиллаж байгаа болохыг дурдсугай.
- Энэхүү тогтоолын дагуу Бондыг нийтэд санал болгохтой холбоотой үйл ажиллагааг зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Цэлмэг)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ



Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны 4-р сарын 25-ны өдрийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 4 дугаар тогтоолын Хавсралт №01



КОМПАНИЙН БОНДЫГ НЭЭЛТТЭЙ ХҮРЭЭНД
ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НӨХЦӨЛ

№	Үзүүлэлт	Нөхцөл
1.	Үнэт цаас	Нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл “Сэндли Бонд 2.0”
2.	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
3.	Үнэт цаасны төрөл	Энгийн хүүтэй бонд
4.	Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	10,000,000,000 (арван тэрбум) төгрөг
5.	Бондын тоо ширхэг	100,000 (нэг зуун мянга) ширхэг
6.	Нэгж бондын нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянга) төгрөг
7.	Бондын хугацаа	24 (хорин дөрөв) сар
8.	Бондын хүү (жилийн буюу 365 хоног)	18.5% (татварын өмнөх)
9.	Хүү төлөгдөх давтамж	Улирал тутамд
10.	Үндсэн төлбөр төлөх хугацаа	Бондын хугацааны эцэст (24 сарын дараа)
11.	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх
12.	Нийтэд санал болгон гаргах хугацаа	2024 оны III улирал (Зохицуулагч байгууллагын зөвшөөрлөөс шалтгаалан өөрчлөгдөж болно)
13.	Бондын хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
14.	Бондын барьцаа/баталгаа	Компанийн толгой компани болох “Монголын финтек групп” ХК нь “Сэндли ББСБ” ХК-д өөрийн эзэмшиж буй 111,785,000 ширхэг энгийн хувьцаа, “Монголын финтек групп” ХК-ийн Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-4 гудамжны 406 тоот хаягт байрлах Улсын бүртгэлийн дугаар Э-0714002972, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237626, нэгж талбарын дугаар 4401010485 бүхий зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар зориулалттай, 10000 м.кв газар эзэмших эрх болон Дорноговь аймгийн Замын-үүд

		сум, 1-р баг Соёмбо, ТЗӨЧ-3 гудамжны 320 хаягт байрлах, Улсын бүртгэлийн дугаар Э-0714002967, газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 0000237326, нэгж талбарын дугаар 4401002556 бүхий Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 1200 м.кв газар эзэмших эрх
15.	Үндсэн андеррайтер	“Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК
16.	Туслах андеррайтер	“Райнос Инвестмент ҮЦК” ХХК болон “Голомт Капитал ҮЦК” ХХК